



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ  
ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо,  
Энхтайваны өргөн чөлөө, Утас/Факс: (976) 7011 2857  
E-mail: nctmmgl@gmail.com

ТӨВ ЭМНЭЛЭГ, ТӨРӨЛЖСӨН  
МЭРГЭЖЛИЙН ТӨВ,  
АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗАР, БОЭТ, НЭГДСЭН  
ЭМНЭЛГИЙН ДАРГА,  
ЗАХИРАЛ НАРТ

2018. 09. 16 № 528  
танай -ны № -т

Эрдэм шинжилгээний бага хуралд  
оролцуулах тухай

Цусны албаны эрдэм шинжилгээний XV бага хурлыг 2018 оны 09-р сарын 18-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулахаар төлөвлөсөн болно.

Иймд та бүхэн өөрийн болон харьяа эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэн, эрдэмтэн судлаачдыг өргөнөөр оролцуулахыг урьж байна.

Хуралд оролцогчдын хүсэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл [surgalt11@gmail.com](mailto:surgalt11@gmail.com) хаягаар хүлээн авна. Эрдэм шинжилгээний бага хурлын удирдамжийг хавсралтаар хүргүүлэв.

Жич: Оролцогчдод 1 багц цаг олгоно.

Та бүхний хамтын ажиллагаанд талархал илэрхийлье.

Хавсралт хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н. ЭРДЭНЭБАЯР

## ЦУСНЫ АЛБАНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХV БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

### Үндэслэл:

Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс 2003 оноос эхлэн эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж байгаа бөгөөд энэ жил 15 дахь удаагаа зохион байгуулах гэж байна.

Энэхүү хурлаар цусны аюулгүй байдал, цус цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээний талаар сүүлийн жилүүдэд хийгдэж буй судалгаа шинжилгээний ажлуудтай танилцах, харилцан туршлага солилцох, тулгамдсан асуудлыг тодорхойлох, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах, тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шинэ арга, технологийг нутагшуулах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд онцгой ач холбогдолтой юм.

### Эрдэм шинжилгээний хурлын чиглэлүүд:

- Эмнэлгийн удирдлага, зохион байгуулалт, нийгмийн эрүүл мэнд
- Эмнэлзүйн цус сэлбэлт, цус цусан бүтээгдэхүүний хэрэглээ
- Донор зохион байгуулалт, цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- Цус сэлбэлтээр дамжих халдвар
- Иммунгематологи, иммуногенетик
- Эсийн эмчилгээ, хүйн банк
- Эмнэлгийн тоног төхөөрөмж, мэдээллийн технологи

### Хамрах хүрээ:

- Цус сэлбэлт судлалын эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн
- Эмнэлзүйн эмч, сувилагч
- Эмгэг судлаач эмч/лабораторийн эмч, мэргэжилтэн
- Био-Анагаахын мэргэжилтэн, судлаач
- Лаборант, техникч
- Тоног төхөөрөмж болон мэдээллийн технологийн инженер
- Багш, судлаач

## Илтгэлийн хураангуйд тавигдах шаардлага:

1. Илтгэлийн хураангуй нь А4 цаасан дээр, Arial фондоор бичигдсэн, үсгийн 12 хэмжээтэй, мөр хоорондын зай 1.5, тал бүрээс 2 см зйттай байна.
2. Үгийн тоо нь зураг, хүснэгт, ном зүйг оруулалгүйгээр 500 үгэнд багтаан бичнэ.
3. **Илтгэлийн нэр:** ТОМ ҮСГЭЭР БИЧНЭ. 100 хүртэл тэмдэгтийг агуулсан байна.  
/Цэг тавьж төгсгөхгүй байх/
4. **Илтгэгчийн нэр, хаяг:** Жишээ нь: Ж.Болд<sup>1</sup>, М.Гэрэл<sup>2</sup>

<sup>1</sup> ЦССҮТ, Технологийн тасаг ....., <sup>2</sup>АШУҮИС, БАС..... гэх мэт

### 5. Илтгэлийн бүтэц:

- Үндэслэл
  - Судалгааны зорилго
  - Судалгааны материал, арга зүй
  - Судалгааны үр дүн (хүснэгт болон зураг оруулахгүй)
  - Дүгнэлт
  - Хэлцэмж
  - Түлхүүр үг: 2-5 үг
6. Илтгэлийг амаар эсхүл ханан хэлбэрээр хэлэлцүүлэх саналаа ирүүлнэ.
  7. Ирүүлсэн бүтээлийг сонгон шалгаруулсны дараа хурал зохион байгуулагчаас илтгэх цаг, албан ёсны урилгыг илгээнэ.
  8. Илтгэлийн хураангуйг 2018 оны 9-р сарын 10-ны дотор [surgalt11@gmail.com](mailto:surgalt11@gmail.com) хаягаар ирүүлнэ.
  9. Холбогдох утас: 70112857, 88005491